



ХӨСӨГ ТРЕЙД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 03 сар 09 өдөр

№ 02

Улаанбаатар хот

Г Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1 дахь заалтууд, 2023 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тэмдэглэл, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх” журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчөөр Д.Нямбаярыг өөрчилж Д.Бадамыг бүртгүүлэхийг компанийн гүйцэтгэх захирал /М.Эрдэнэсүх/-д зөвшөөрсүгэй.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 11 цаг 30 минутад Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо Сэнтрал тауэр 902 тоот Хурлын танхимд хуралдуулахаар тогтоож компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай.
 - Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
 - Ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах;
 - Компанийн одоо эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлүүдийг хасах
 - Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлийг дүрэмд нэмэх
 - Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 03 сарын 31-ний өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр нийтэд мэдээлж, уг зарыг 2023 оны 03 сарын 29-ны өдөр дахин нийтэд мэдээлсүгэй.
5. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /Б.Анхбаяр/-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.
6. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурдсугай.

7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ны агуулгыг хавсралт 2-д зааснаар баталсугай.
8. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 17.30 цагаар тасалбар болгосугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хурал зохион байгуулах болон тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:
 - С.Болор Хурлын дарга
 - Б.Анхбаяр Хурал зохион байгуулах комиссын дарга
 - Б.Гэрэлмаа Тооллогын комиссын дарга
 - Э.Шатар Гишүүн
10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс-д даалгасугай.
11. Хурлын зарын загвар, хэлэлцэх асуудлыг Хавсралт 3-аар баталсугай
12. Хурлын дэгийг Хавсралт 4-өөр баталсугай.
13. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Хавсралт 5-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Б.Анхбаяр/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.БОЛОР